



# ИЛТГЭХ ХУУДАС



*“Стратеги төлөвлөгөө-2050”-д,  
үнэлгээ хийсэн тухай  
/2024 оны III улирал/*

2024 он



АУДИТ ХИЙГДСЭН ГАЗАР:

ТЭЭВРИЙН УЛИРДЛАГЫН ГАЗАР  
САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР  
ТӨСӨЛ ХӨГЖЛИЙН ГАЗАР  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

АУДИТЫН ТӨРӨЛ:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

АУДИТЫН ХУГАЦАА:

/2024.11.07-2024.11.12/

ТАНИЛЦСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.БУДБАЯР

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА:

Н.МӨНХСҮРЭН

АУДИТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТОР

Л.УУГАНЦЭЦЭГ

2024 оны 11 дүгээр сарын 12

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн “Стратеги төлөвлөгөө-2050”-ийг хэрэгжүүлэх нэгдүгээр үе шат (2021-2024 он).

2024 оны III улирлын байдлаар нийт 9 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 100 хувьтай хэрэгжсэн-15, 90 хувьтай хэрэгжсэн-8, 70 хувь хэрэгжсэн-8, 50 хувь хэрэгжсэн-3 арга хэмжээ байна. Нийт хэрэгжилт 88 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэй байна.

Хүснэгт 1.

Нийт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	Хугацаа болоогүй	
34	15	8	8	3	-	88%

Цаашид хөтөлбөрийн 70, 50 хувийн хэрэгжилттэй байгаа дараах арга хэмжээг эрчимжүүлж ажиллах шаардлагатай.

**Тэргүүлэх чиглэл-2-ын** 2.1-д туссан “Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, барилгын ажлыг чанар стандарт төлөвлөгөөний дагуу эхлүүлэх арга хэмжээ **70 хувьтай** ажлыг зохион байгуулах.

**Тэргүүлэх чиглэл-3-ын** 3.3, 3.4-д туссан Тээвэрлэх ачааны хэмжээг жил бүр 5 сая тонноор нэмэгдүүлж, 2024 онд 15 сая тоннд хүргэх арга хэмжээ **50 хувьтай** байгаа нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зүтгүүрийн нийлүүлэлт хийгдээгүй удсан, “ТНАЛТ” төсөл ашиглалтад ороогүй, хил холболт хийгдээгүй зэрэг шалтгааны улмаас төлөвлөгөөний хэрэгжилт хангагдахгүй, төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байгаа шалтгаан болсон.

**3.5-д** туссан 2 сэлгээний зүтгүүр худалдан авах арга хэмжээ **70 хувьтай** байгааг эрчимжүүлэх.

**Тэргүүлэх чиглэл-5-ын** 5.1-д туссан Төмөр замын зүүн коридор (Чойбалсан-Хөөт-Бичигт) чиглэлийн төмөр замтай холбогдох судалгааны ажлууд, ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулж, баталгаажуулсан байх арга хэмжээ **70 хувьтай** “Хөдлөх бүрэлдэхүүн угсрах үйлдвэр технологийн төв” төслийн Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, “Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн” чиглэлийн төмөр замын төслийн Техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг тус тус боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

**Тэргүүлэх чиглэл-8-ын 8.3-д** туссан Компанийн удирдлагын зарим чиг үүрэгт мэдээллийн технологид суурилсан ERP систем нэвтрүүлсэн байна арга хэмжээ **50 хувьтай** байна Компанийн удирдлагын зарим чиг үүрэгт мэдээллийн технологид суурилсан able системийг 2024.03.01-ний өдрөөс эхлэн “Эйблсофт” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хүрээнд эйбл системд цаг бүртгэлийн программ, Хүний нөөцийн программын нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэгчээс гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлж, хяналт тавин хүлээн авах нь зүйтэй.

### **ЗӨВЛӨМЖ:**

Цаашид хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл-6 буюу Компанийн хүний нөөцийн хөгжил зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа арга хэмжээ болон тэргүүлэх чиглэл-8 Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа арга хэмжээний үр дүнг идэвхжүүлэн ажиллах.

**Тухайлбал** Хүний нөөцийн бүрдүүлэлтийг чадварлаг, бүтээлч, мэргэшсэн байдлаар сонгох, ажилчдыг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.



Компанийн зарим чиг үүрэгт мэдээллийн технологид суурилсан ERP систем нэвтрүүлсэн байх арга хэмжээний хүрээнд хийгдэж буй ажил удаашралтай үр дүн хангалтгүй байгаа тул илүү хэрэгцээ шаардлагатай системийг нэвтрүүлж, санхүү, мэдээллийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.

- Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Төсөл хөгжлийн газар нь бусад газар, хэлтэс албанаас нэгтгэн заасан хугацаанд Засгийн газрын 206 дугаар тогтоолд заасны дагуу 2000 тэмдэгтэд багтаан, товч бөгөөд тодорхой ирүүлж хэвших;
- Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатанд төлөвлөгдсөн ажлууд 2024 онд дуусаж байгаа тул Төсөл, хөгжлийн газар, Тээврийн удирдлагын газрууд гэрээнд заасан хугацаанд дуусаагүй байгаа төслүүдийн гүйцэтгэлийг ерөнхий гүйцэтгэгчээс шаардаж, дуусгах ажлыг зохион байгуулах;
- Цаашид Төсөл, хөгжлийн газар нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёрдугаар үе шатанд (2025-2028 онд) хийгдэх ажлын төлөвлөгөөг гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвараар боловсруулан батлуулах, 2025 онд хийгдэх ажил, арга хэмжээг Төсөл, хөгжлийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, Нэгдүгээр үе шатанд (2022-2024 он) хийгдсэн ажлын хэрэгжилтийн хамт ХШҮДАА-нд 2025 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн дотор багтаан ирүүлэх;

“Стратеги төлөвлөгөө-2050”-ын /2024 оны 3 дугаар улирлын байдлаар/ хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 13 хуудастай.

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН “СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ-2050”  
ХӨТӨЛБӨРИЙН I ҮЕ ШАТ БУЮУ 2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2024.11.12

Хавсралт-1

№	Төлөвлөгдсөн хийгдэх ажлууд	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Биелэлт /хувиар/
<b>Нэг. Стратеги төлөвлөгөөний үе шатуудад хүрэх түвшин</b> <i>Үр дүн: Төслийн компаниас суурь бүтэц тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэгч компани болох</i>				
1.	Олон улсын стандарт нэвтрүүлэгч байгууллагын статустай болсон байна.		-Компанийн хэмжээнд “ISO9001:2015”, “ISO45001:2018”, “ISO14001:2015” стандартуудын багц журмуудыг боловсруулан батлуулж, сургагч багш нартай хамтран оффис, төслийн талбайд ажиллаж буй нийт ажилтнуудад сургалт зохион байгуулсан. “ISO21500:2012”, “ISO27001:2013” стандартуудын багц журмууд боловсруулагдаж төлөвлөгөө гарган ажилласан. 2022.04.19-ны А/43 дугаар тушаалаар Дотоод аудит хийх ажилтнуудын нэрсийг батлуулж, баталгаажуулалтын аудитад бэлтгэх бэлтгэл ажил хийгдсэн. Дээрх батлагдан гарсан багц журамтай 3 стандартын хэрэгжилтийг хангах, баталгаажуулах үүднээс болзолт уралдааныг санаачлан төлөвлөж, удирдамжийг Гүйцэтгэх захирлаар батлуулсан. 2022.10.17-ны өдөр ISO27001:2013, ISO21500:2012, ISO9001:2015, ISO14001:2015, ISO45001:2018 олон улсын стандартуудыг тус тус нэвтрүүлж, олон улсын баталгаажилтын гэрчилгээг хүлээн авсан.	100%  ТХГ
2.	Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авч, зүгшрүүлэлт хийж, ашиглалтад оруулсан байна.		-Зүтгүүрийн паркийг бүрдүүлэхээр “Бодь Интернэшнл” ХХК нь EPC гэрээнд заасан нийт ажлын 9.85%-ийг эзэлж буй тус багц ажлын хүрээнд АНУ-ын Progress Rail компаниас SD70ACe/LW серийн 16 ширхэг зүтгүүрийг манайд нийлүүлсэн. МТЗ ТӨХК-д 2 зүтгүүр, УБТЗ ХНН-д 2 зүтгүүр нийт 4 зүтгүүр түрээсээр, ТТ-ГС-ТТ чиглэлийн тээвэрлэлтэд 4 зүтгүүр, 2 зүтгүүр төлөвлөгөөт бус засварт орсон. Зүтгүүрийн депод 6 зүтгүүр зүгшрүүлэлт хийгдэж байна. 10,11 сард багтаан ашиглалтад хүлээн авахаар төлөвлөж байна. -Вагон паркийг бүрдүүлэхээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд ерөнхий гүйцэтгэгчтэй хийсэн ажил гүйцэтгэх EPC гэрээний хүрээнд нийт 812 ширхэг хөдлөх бүрэлдэхүүн (400 хагас вагон, 390 тавцант вагон, 13 хашлагатай тавцант вагон, 8 битүү вагон, GСУ-300K загварын 1ш өөрөө явагч)-ийг бүрэн хүлээж авсан. Хүлээн авалтын гүйцэтгэл 100 хувьтай. Түүнчлэн 812 вагоны хувийн дугаар болон Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 811 вагоны объектын гэрчилгээг ГТХЗНТ-с авсан.	90%  ТУГ
3.	Тээвэр зуучлалын үйл ажиллагааг эхлүүлнэ.		-2023.03.02-ны өдөр ЗТХЯ-ны төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх “Төмөр замын тээвэр зуучлалын тусгай зөвшөөрөл” авсан.	100%

			-Тээвэр зуучлалын үйл ажиллагааны хүрээнд “Цемент Шохой” ХХК-тай 2023.11.03-ны өдөр, “Өгийг гүрэм” ХХК-тай 2023.12.13-ны өдөр, “Эйр кейтеринг” ХХК-тай 2024.01.31-ний өдөр, “Ялгуун лайм” ХХК, 2024.01.31-ний өдөр, “Мак цемент” ХХК-тай 2024.02.20-ны өдөр, “Дулаан түгээх хөгжил” ХХК-тай 2024.03.05-ны өдөр, “Алэйл Экспресс” ХХК-тай 2024.06.10-ны өдөр, “Мандах өглөө” ХХК-тай 2024.07.06-ны өдөр тус тус Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх 8 гэрээг байгуулан тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна.	
<b>Хэсгийн дундаж хувь:97%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-1: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт</b>				
<i>Үр дүн: 2020 оны 07 дугаар сард Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 240 км төмөр замыг ашиглалтад оруулна. Уг төмөр зам дагалдах зарим объектууд ашиглалтад орсон байх</i>				
1.1.	I зэрэглэлийн 234.9 км урт, 1,520 мм-ийн царигтай 18 галт тэрэг нэвтрүүлэх хүчин чадалтай замыг 2022 оны 7 дугаар сард ашиглалтад оруулна.	Тус чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ажлыг хүлээн авах	Тавантолгой-Гашуунсухайт төслийн Ачилтын тойрог-1, Тавантолгой өртөө ПК0+000 –ПК230+640 км хүртэлх Багц 1-2 БХБЯ-ны 2023.05.19-ний өдрийн А/125 дугаар тушаалын дагуу Улсын комисс ажиллан 2023.06.20-ны өдрийн 2023/006 дугаартай албажин байнгын ашиглалтад хүлээн авсан.	100% СБГ
1.2.	Вагон парк дахь нийт вагоны тоо 810 ширхэг байна.  Гол замын зүтгүүрийн тоо 16 ширхэг байна.  Сэлгээний зүтгүүрийн тоо 2 ширхэг байна.	Хөдлөх бүрэлдэхүүний худалдан авалт, зүгшрүүлэлт	<b>Вагон парк дахь нийт вагоны тоо 810 ширхэг байна.</b> Вагон паркийг бүрдүүлэхээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд ерөнхий гүйцэтгэгчтэй хийсэн ажил гүйцэтгэх ЕРС гэрээний хүрээнд нийт 812 ширхэг хөдлөх бүрэлдэхүүн (400 хагас вагон, 390 тавцант вагон, 13 хашлагатай тавцант вагон, 8 битүү вагон, GСУ-300K загварын 1ш өөрөө явагч)-ийг бүрэн хүлээж авсан. Хүлээн авалтын гүйцэтгэл 100 хувьтай. Түүнчлэн 812 вагоны хувийн дугаар болон Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 811 вагоны объектын гэрчилгээг ГТХЗНТ-с авсан. <b>Гол замын зүтгүүрийн тоо 16 ширхэг байна.</b> ЕРС гэрээний хүрээнд 16 ширхэг SD70Ace/LW илчит тэргийг 2024 онд хүлээн авна. 2024.02.29-нд SD70Ace/LW-4101. SD70Ace/LW-4102 дугаартай 10 зүтгүүрийг хүлээн авсан. 2024.09.24-ний өдөр үлдсэн 6 зүтгүүрийг хүлээн авсан. <b>Сэлгээний зүтгүүрийн тоо 2 ширхэг байна.</b> “Тавантолгой-Гашуунсухайт”, “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын төслийн хүрээнд “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь Интернэйшнл” ХХК нь 2021.08.20-ны өдөр ВI-ТТЗВ-СОНТ-0001, ТТЗ-Н21/01 тоот гэрээгээр 1 ш сэлгээний зүтгүүрийг авахаар тохиролцсон. -2022.01.18-ны өдөр АНУ-ын “National Railway Equipment” Inc компанийг сонгон 2GS16С серийн зүтгүүрийн захиалга өгсөн. -2023.05.12-ны өдрийн мэдээгээр нийт гүйцэтгэл 45%-тай, COVID-19-ийн нөлөөгөөр сэлбэг хэрэгслийн нийлүүлэлт хойшилсон, ажиллах хүчний дутагдалтай холбоотойгоор хугацаа нь 10 хүртэлх сараар хойшлох болсон тухай мэдэгдсэн.	90% ТУГ ТХГ

			<p>-2023.11.10-ны өдрийн мэдээгээр 2023 оны 05-р сард “NRE” компанийн эд хөрөнгө, тэдгээрийн дагалдах эрхүүдийг АНУ-ын “TRM Equity” LLC компани шилжүүлсэн бөгөөд “TRM Equity” LLC компани нь “TRM NRE” нэртэйгээр сэлгээний зүтгүүрийг үргэлжлүүлэн үйлдвэрлэх гэрээг 2023 оны 08 дугаар сард байгуулснаа мэдэгдсэн.</p> <p>-2024.03.06-ны өдөр ирүүлсэн мэдээгээр нийт гүйцэтгэл 54%-тай ирэх хугацаа 2025.03.12-ны өдөр гэж мэдэгдсэн.</p>	
<b>Хэсгийн дундаж хувь:95%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-2: Хил холболтын төмөр зам</b>				
2.1.	<p>“Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, барилгын ажлыг чанар стандарт төлөвлөгөөний дагуу эхлүүлэх</p>	<p>ТЭЗҮ, магадлагдсан зураг төсөл</p>	<p><b>1.Техник, эдийн засгийн үндэслэл магадлуулах ажлын хүрээнд:</b>  ЗТХЯ-наас 2023.09.29-ний өдөр №08/4591 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны ШУ технологийн зөвлөлөөр хэлэлцэн дэмжигдсэн. ЗТХЯ-наас 2023.09.29-ний өдөр ирүүлсэн чиглэлийн дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг тус төслийн нарийвчилсан зураг төсөл магадлуулах хүрээнд “магадлуулах” нь зүйтэй хэмээн мэдэгдсэн.  ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан магадлуулах шаардлагатай талаар “Хятадын төмөр замын зураг төслийн корпораци” ХХК-д 2024.06.14-ний өдрийн №2/1625, 2024.08.19-ний өдрийн №1/2135 дугаартай албан бичгээр удаа дараа хандаж байсан. Үүнтэй холбогдуулан “Хятадын төмөр замын зураг төслийн корпораци” ХХК нь “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай ТЭЗҮ-ийг магадлуулах ажлын зардлыг харилцан тохиролцоогүй, гацаанд орсон шаардаж буй төлбөр хэт өндөр байгаа тухай 2024.08.21-ний өдөр №CRDCMN/PS/2024-55 дугаартай албан бичгээр тайлбарласан.  Энэ хүрээнд “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Хятадын төмөр замын зураг төслийн корпораци” ХХК хооронд гурван талт уулзалтыг 2024.09.25-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтаар зураг төслийн гүйцэтгэгчийг ТЭЗҮ магадлуулах шаардлагыг тавин ажилласан.</p> <p><b>2.Иж бүрэн зураг төсөл боловсруулах, магадлуулах ажлын хүрээнд:</b>  Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын нарийвчилсан зураг төсөл, төсвийг магадлуулах ажил 2024.04.18-ны өдрөөс эхлэн хийгдсэн. Одоогийн байдлаар Төмөр замын дээд, доод бүтэц, Гүүр болон хоолой, Эрчим хүч, Барилга байгууламж /блок 1, 2, 3, 4, 8, 9, 13, 14/, Авто замын зураг төсөл болон төсвүүд бүрэн магадлагдаж, Захиалагчид хүлээлгэн өгсөн.  Тоног төхөөрөмжүүдийн төсөв болон /блок 5, 6, 7, 10, 11, 12, 15, 16, 17, 18, 19/ барилга байгууламжийн зураг төсвүүд Магадлалын ерөнхий дүгнэлт боловсруулагдаж байна.</p> <p><b>3.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн</b> төсөлд МУЗГХЭГ-ын даргын 2023 оны 104 дугаар тушаалаар байгуулагдсан “Төмөр замын холболтын</p>	<p>70%</p> <p>ТХГ</p>

			<p>бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий” Ажлын дэд хэсгийн гишүүдийн саналыг тусган “Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХК-тай 2024.06.05-ны өдөр цахим хурлыг зохион байгуулсан.2024.06.06-ны өдөр эцэслэн санал солилцсон. Хятадын талаас хэлэлцээрийг хоёр талын ажлын хэсгийн ахлагч нар эцэслэх нь зүйтэй гэж үзсэн. Энэ хүрээнд хэлэлцээрийн төслийг эцэслэж өгөх хүсэлтийг 2024.06.07-ны өдрийн 1/1568 дугаартай албан бичгээр Төмөр замын холболтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн ахлагчид хүргүүлсэн.</p> <p>Мөн Монгол Улсын Засгийн газрын ХЭГ-ын даргын 2024.08.21-ний өдрийн 69 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын дэд хэсгийн хуралдаанаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төслийн талаарх танилцуулга, холбогдон гарах хуралдааны шийдвэрийн төслийн саналыг боловсруулан 2024.08.30-ны өдрийн 1/2233 дугаартай албан бичгээр ажлын дэд хэсгийн ахлагчид хүргүүлсэн.</p> <p>“Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХК-иас 2024.09.30-ны өдөр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл”-ийн 1.4-т “Монголын талын хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчээр Хятадын хил доторх Хятадын талын тодорхойлсон Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгож болох бөгөөд Монголын талын барилгын ажил гүйцэтгэх гэрээг “Тавантолгой төмөр зам” ХХК болон гүйцэтгэгч нар харилцан тохиролцож гарын үсэг зурна” хэмээн өөрчлөлт оруулан, 4.9-д “Хилийн хамгаалалтын бүсийн хашаан доторх барилгын ажлын цар хүрээг төмөр замын шугамыг төв болгож, баруун, зүүн тийш 50 метрийн зайд тус тус тогтоох бөгөөд хоёр талын компани нь өөр өөрийн хилийн хамгаалалт, хилийн шалган нэвтрүүлэх, гааль зэрэг байгууллагуудыг хариуцаж барилга угсралтын ажилд үйлчилгээ үзүүлнэ” нэмэлтээр тус тус ирүүлсэн байна. Тус 4.9 дэх заалтын хүрээнд хэлэлцээрийн төсөлд санал авахаар 6/2497, 6/2498 дугаартай албан бичгээр Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт хүргүүлэн санал авсан.</p> <p><b>4.Санхүүжилтийн гэрээний талаар</b></p> <p>Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх хүрээнд МУ-ын ЗГ-ын 2024.08.21-ний өдрийн 28 дугаар тэмдэглэлд эрчимжүүлэх чиглэл өгсний дагуу санхүүжилтийн 3 талт гэрээний төслийг хамтран боловсруулах шаардлага үүссэнтэй холбогдуулан бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх хүрээнд холбогдох гэрээ, хэлэлцээрт хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтарсан ажлын хэсэг байгуулах хүсэлтийг 2024.09.17-ны өдөр 1/2360 дугаартай албан бичгээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хүргүүлсэн. Энэхүү хүсэлтийн дагуу хамтарсан ажлын хэсэг байгуулах саналыг “Эрдэнэс Тавантолгой” ХК дэмжсэн ба гэрээний төслийг боловсруулан ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--



2.2.	“Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор газар ашиглах асуудлыг шийдвэрлүүлэх		2024.02.07-ны өдөр 24/32 дугаартай газар ашиглах гэрээг Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулж БОАЖЯ-ны Тусгай Хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газраар батлуулсан.	100% ТХГ
2.3.	“Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын төсөл, “Гашуунсухайт шилжүүлэн ачих терминал төсөл”-ийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г батлуулах		2024 оны I дүгээр улиралд “Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төсөл”-ин БОННУ, “Шилжүүлэн ачих терминал төсөл”-ийн БОННУ тус тус батлагдсан.	100% ТХГ
<b>Хэсгийн дундаж хувь:90%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-3: Төмөр зам, үйлчилгээ</b>				
<i>Үр дүн: “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн болон түүнтэй холбогдох төмөр замын сүлжээнд суурь бүтэц ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг бие даан эрхлэн явуулах түвшинд хүрсэн байна.</i>				
3.1.	Багц дүрэм, журмууд: -Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын – 31; -Замын аж ахуй – 24; -Дохиолол холбоо, эрчим хүч, ус хангамж – 10; -Зүтгүүрийн аж ахуйн – 50 дүрэм журмууд. Эдгээрийг 2022 оны 7 дугаар сард боловсруулж батлуулсан байна.	Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар гарсан байдал	-Ачаа тээврийн чиглэлээр 32, хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр 29 дүрэм, журмыг батлуулж, мөрдөн ажиллаж байна. -Зүтгүүр ашиглалттай холбоотой багц 24 дүрэм, журам, заавар батлуулж, мөрдөн ажиллаж байна. -2024 онд Вагоны аж ахуйн хэмжээнд засвар, ашиглалтын чиглэлээр нийт 58 ш технологийн баримт бичиг боловсруулсан. Гүйцэтгэх захирлын 2024 оны А/73 дугаартай тушаалын дагуу засвар, ашиглалтын чиглэлээр технологийн горим 9-ийг шинэчлэн боловсруулж, батлуулсан. Нийт батлуулсан баримт бичиг 49 ш.	100% ТУГ
3.2.	-2022 оны 7 сард 871 ажилтан. -2024 онд 1239 ажилтан. “Чойбалсан-Хөёт-Бичиг” чиглэлийн төмөр замын ажилтнуудыг тус тус бэлтгэж эхэлсэн байна.	Холбогдох мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлсэн байдал	<b>2022 онд</b> Компанийн 461 ажилтантай үүнээс 39-ажилтантай “Хөлсөөр ажиллах гэрээ” байгуулан ажилласан. <b>2024 онд</b> үндсэн ажилтан 750, Хөлсөөр ажиллах гэрээгээр 65 ажиллаж байна. Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 116 дугаар тогтоолоор “Чойбалсан-Хөёт-Бичиг” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компани байгуулах асуудлыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасан.	100% ЗУГ
3.3.	<ul style="list-style-type: none"> <li>2022 онд 5 сая тонн нүүрс тээвэрлэнэ.</li> <li>Тээвэрлэх ачааны хэмжээг жил бүр 5 сая тонноор</li> </ul>	“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ачаа тээвэрлэлт	2022 оныд 07 дугаар сарын .09-ний өдрөөс туршилтын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эхэлж ТТ-ГС чиглэлд 5 сая.тн ачаа тээвэрлэхээр төлөвлөснөөс 143 мян.тн, ТТ-ЗБ чиглэлд 1,4 сая.тн ачаа тээвэрлэхээс 121 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.	50% ТУГ

	нэмэгдүүлж, 2024 онд 15 сая тоннд хүргэнэ.		<ul style="list-style-type: none"> <li>2023 онд тус хөтөлбөрт ТТ-ГС чиглэлд 10 сая.тн ачаа тээвэрлэхээс 639 мян.тн, ТТ-ЗБ чиглэлд 1,4 сая.тн ачаа тээвэрлэхээс 1,3 сая.тн ачаа тээвэрлэсэн үзүүлэлттэй байна</li> <li>2024 онд тус хөтөлбөрт ТТ-ГС чиглэлд 10 сая.тн ачаа тээвэрлэхээс өнөөгийн гүйцэтгэл 1193,936 мян.тн, ТТ-ЗБ чиглэлд 1,4 сая.тн ачаа тээвэрлэхээс өнөөгийн гүйцэтгэл 643.354 мян.тн ачаа тээвэрлэсэн үзүүлэлттэй байна.</li> <li>ТТ-ЗБ чиглэл буюу МТЗ-ын Цогтцэцийн өртөөтэй 1316 галт тэрэг солилцсон.</li> </ul>	
3.4.	2021-2024 онд жилд дунджаар 1.4-3.5 сая тонн нүүрс тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлнэ.	“Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замтай галт тэрэг солилцоо		50% ТУГ
3.5.	2 сэлгээний зүтгүүр худалдан авна.	Хөдлөх бүрэлдэхүүний худалдан авалт	Сэлгээний 1 ширхэг зүтгүүр төслийн ЕРС гэрээний хүрээнд нийлүүлэгдэхээр NRE компанийн 2GS16С серийн зүтгүүр 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авахаар төлөвлөж байна.	70% ТУГ
3.6.	-2024 онд Гашуунсухайт, Тавантолгой өртөөд болон 4-р зөрлөгт зорчигчийн нам тавцан баригдсан байна. -2024 онд Гашуунсухайт өртөөнд зорчигч үйлчилгээний төв баригдсан байна. -2024 онд 2 ширхэг суудлын вагон худалдаж авна.	Зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа	-2024 оны хөрөнгө оруулалтын төсөвт 1 ширхэг суудлын вагон худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.  -2024 онд Гашуунсухайт, Тавантолгой өртөөнд зорчигчийн нам тавцан барих хөрөнгө оруулалтын тооцоо хийгдсэн ба 2025 оны төсөвт суулгах саналыг ЗБХ-с хүргүүлсэн. 4-р зөрлөгт зорчигч үйлчилгээний талаар төлөвлөгөө байхгүй. Гашуунсухайт өртөөнд зорчигч үйлчилгээний төв баригдах хэрэгцээ шаардлага, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хэрэгтэй байна.	70% ТУГ
3.7.	-Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авч, зүгшрүүлэлт хийж ашиглалтад оруулсан байна. -Ачилт, буулгалтын цогц байгууламжийг олон улсын стандарт шаардлагын дагуу бүтээн байгуулж, ашиглалтад оруулсан байна. -Шинэ төмөр замын төслийн хүрээнд уулзваргүй замын технологийг нэвтрүүлсэн, арчилгаа үйлчилгээг хийх дадал чадварыг эзэмшсэн байна. -Дэлхийд танигдсан технологийн хөдлөх бүрэлдэхүүнд үйлчилгээ хийх зориулалт бүхий орчин үеийн засварын төвийг ашиглалтад	Үйл ажиллагааны шинэ техник, технологи нэвтрүүлсэн байна.	-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл ЕРС гэрээний дагуу 810 вагон бүрэн нийлүүлэгдэж гэрчилгээжүүлэлт авч орон нутгийн болон олон улсын тээвэрлэлтэд оролцуулан ашиглаж байна. Мөн нийлүүлэгдэх 16 ширхэг АНУ-ын Прогресс райл үйлдвэрээс нийлүүлэгдэх зүтгүүрийн 16 хүлээн авч зүтгүүрийг зүгшрүүлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна. -“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Чайна энержи ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХК нарын хооронд байгуулах Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай ерөнхий хэлэлцээрт жилд 10 сая.тн нүүрс тээх хэмжээний эргэдэг автоугсраатай вагон буюу компанийн эзэмшлийн вагонуудаас өөр вагон ашиглах асуудлыг тусгасантай холбоотойгоор өөрийн эзэмшлийн вагонуудын ашиглалтыг бууруулахгүйн тулд эргэдэг автоугсраатай вагон угсрахаар Гүйцэтгэх захирлын 2024 оны А/116, А139 ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. -Гашуунсухайт өртөөний дэргэд Шилжүүлэн ачих терминалын төслийг хэрэгжүүлэн төслийн гүйцэтгэл 99 хувьтай байна. -Уулзваргүй замын арчлалт үйлчилгээний хүрээнд шаардлагатай баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байгаа ба ЗТХЯ-аас МУ-ын хэмжээнд уулзваргүй замыг гагнах альминотермит болон флаш бат гагнуурын стандартын төслийг бэлтгэж байгаа.	90% ТУГ

	оруулж, засварын шинэлэг систем, зөв хандлагаар ажилтнуудаа төлөвшүүлсэн байна.		-Хөдлөх бүрэлдэхүүний засварын төвийг ашиглалтад оруулан вагон, зүтгүүр засах, шинэ тоног төхөөрөмж суурилуулах, зүгшрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
<b>Хэсгийн дундаж хувь:76%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-4: Логистикийн үйл ажиллагаа</b>				
<i>Үр дүн: Төмөр замын тээвэрлэлтийг гүйцэтгэх дэд бүтцийн болон логистикийн байгууламжуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулсан байх, Ачих болон буулгах терминал шилжүүлэн ачих байгууламжуудад тулгуурласан логистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байх</i>				
4.1.	-Ачилтын тойрог замаар нүүрс ачих үйл ажиллагааг эхлүүлсэн байна. -Тавантолгой өртөөнд ачих, буулгах терминал баригдсан байна. -Гашуунсухайт өртөөнд өндөр зам баригдсан байна. -Гашуунсухайт боомтод ачих, буулгах, шилжүүлэн ачих байгууламж баригдсан байна.	Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг явуулдаг байдал	-Ачилтын тойрог замд ТНАЛТ ашиглалтад орох хүртэл Түр ачилтын терминалыг байгуулан төмөр замын тээвэрлэлтийн тасралтгүй үйл ажиллагааг гүйцэтгэж байна. ТНАЛТ төслийн бүтээн байгуулалтын ажил дуусаж хэд хэдэн удаа туршилтын ажил хийгдсэн. -Гашуунсухайт өртөөнд өндөр зам барих хэрэгцээ шаардлага байхгүй. -Шилжүүлэн ачих байгууламж баригдсан.	100%  ТУГ
4.2.	-Тээвэр зуучлалын үйл ажиллагааг эхлүүлсэн байна. -Гаалийн зуучлалын үйлчилгээг эхлүүлсэн байна. -Хамтран ажиллах компаниудтай гэрээ, хэлэлцээ хийгдсэн байна. -ТТ-ГС, ТТ-ЗБ чиглэлийн төмөр замаар тээвэрлэх нүүрснээс бусад ачааны 30-50 хувийг тээвэр зуучлалын үйлчилгээгээр дамжуулан тээвэрлэсэн байна.	Олон улсын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлсэн байдал	<b>Давхацсан асуулт.</b> Гаалийн хамтын ажиллагаа: Тавантолгой өртөө, Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалыг гаалийн хяналтын бүсээр тогтоолгох тухай албан хүсэлтийг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1730 тоот албан тоотоор болон тусгай зөвшөөрлийн нэгдсэн системээр Гаалийн хяналтын бүсээр тогтоолгох тухай хүсэлтээ хүргүүлсэн. Гаалийн ерөнхий газрын 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/428 тушаалаар “Шилжүүлэн ачих терминал”-ыг гаалийн хяналтын бүсээр тогтоосон.	100%  ТУГ
4.3.	Цахим программ хангамжийг нэвтрүүлсэн байна.  Хэрэглэгчдэд зориулсан аппликейшн хөгжүүлсэн байна.	Логистик тээвэр зуучлалын хүрээнд шинэ технологи нэвтрүүлсэн байдал	2024.08.27-ны өдөр Тээврийн программ хангамж хөгжүүлэх, нэвтрүүлэх ажил гүйцэтгэх АГГ-2024/45 дугаар бүхий гэрээг “Амирбаяр” ХХК-тай байгуулсан. Программ хангамжийг нэвтрүүлэхтэй холбоотой гэрээний үүргийг биелүүлэх, программ хангамжийг эцсийн байдлаар хүлээлцэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Үйл ажиллагаанд нэвтрүүлэх, зүгшрүүлэх ажил хийгдэж байна. Дэд хэрэглэгчийн аппликейшн хөгжүүлэх ажил хийгдэж байна. Хэрэгжилтийн явц: 2024.10.28-ны өдрийн байдлаар суурь системийн шинжилгээ болон админы программ хангамж бүрэн хийгдсэн. Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалт	100%  ТУГ ССХХ

			болон зүтгүүрийн ашиглалтын программууд туршилтын байдлаар үйл ажиллагаанд нэвтэрсэн, хөгжүүлэлт хийгдэж байна. (Статистик систем хөгжүүлэлтийн хэлтэс)	
4.4.	-“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нүүрс тээврийг хил хүртэлх тээвэрлэлтийн “DAP” Ганцмод нөхцөлөөр гүйцэтгэнэ. -Нүүрснээс бусад ачааны хувьд гуравдагч талын логистикийн үйлчилгээ /3PL/-г үзүүлнэ.	Логистикийн иж бүрэн хэлхээг бүрдүүлсэн байдал	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нүүрс тээврийг хил хүртэлх тээвэрлэлтийн “DAP” Ганцмод нөхцөлөөр тээвэрлэх эрх зүйн орчин, үнэ тарифын судалгааг хийж байна. Нүүрснээс бусад ачааны хувьд гуравдагч талын логистикийн Тээвэр зуучлалын үйлчилгээг үзүүлж байна.	70%  ТУГ
<b>Хэсгийн дундаж хувь:93%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-5: Судалгаа, инноваци</b>				
<i>Үр дүн: Төмөр замын бүтээн байгуулалтын талаар судалгаа хийх мэдлэг, чадвар, туршлага бүхий зураг төсөл, судалгааны чадавхи, түүний дэд бүтэц бүрдсэн байх</i>				
5.1.	Төмөр замын зүүн коридор (Чойбалсан-Хөөт-Бичигт) чиглэлийн төмөр замтай холбогдох судалгааны ажлууд, ТЭЗҮ-ийн судалгааг боловсруулж, баталгаажуулсан байна.	Төмөр замын бүтээн байгуулалтын чиглэлээр судалгаа хийгдсэн байдал	Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”-тай уялдуулан УИХ-ын 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-д нэмэлт өөрчлөлт оруулах, экспортыг нэмэгдүүлэх, шинээр төмөр замын сүлжээг өргөжүүлэх нөхцөл боломжийг судлах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.12.12-ны өдрийн А/326 тоот тушаалаар байгуулсан. Уг ажлын хүрээнд Даланзадгад-Нарийнсухайт чиглэлийн төмөр зам, Алтай-Бургастай, Алтай-Хөшөөт-Булган, Хөшөөт-Ховд-Цагааннуур чиглэлийн шинэ төмөр замуудын судалгааг хийсэн. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.02.07-ны өдрийн А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт компанийн төлөөлөл оролцон Зорчигч тээвэрлэлтийн судалгааны ажлыг хийж байна. 2024.09.05-ны өдрийн гүйцэтгэх захирлын А/138 тоот тушаалаар “Хөдлөх бүрэлдэхүүн угсрах үйлдвэр технологийн төв” төслийн Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (ТЭЗҮС) боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 2024.10.04-ны өдрийн гүйцэтгэх захирлын А/160 тоот тушаалаар “Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн” чиглэлийн төмөр замын төслийн Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (ТЭЗҮС) боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	70%  ТХГ
5.2.	Судалгааны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, магистраас дээш зэрэгтэй ажилтны тоог 5-10 хувиар нэмэгдүүлэх	Компанийн судлаачдын мэргэжлийн түвшин, чадвар ахисан байдал	Компанийн хэмжээнд судалгааны чиглэлээр мэргэшсэн ажилтан 8, үүнээс 2 нь магистрын боловсролтой байна.	90%  ЗУГ ХНСХ



5.3.	Гадны мэргэжилтэн, судлаачидтай хамтран ажилласан төсөл, хөтөлбөрийн тоо	Үндэсний болон олон улсын түвшинд хамтран ажилласан байдал	<p>2021-2022 онд Богдхан төмөр замын ТЭЗҮ боловсруулах болон Төмөр замын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлын талаарх эрдэм шинжилгээний ажлын хэсэгт зөвлөх судлаачид болон компанийн мэргэжилтнүүд зохион оролцуулан ажиллуулсан.</p> <p>Компанийн бизнес төлөвлөгөө болон бусад төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гадны зөвлөх, судлаачтай хамтран ажиллаж байна.</p> <p>Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан холболтын төмөр замын ТЭЗҮ-г Хятадын “Төмөр замын зураг төслийн корпораци” компанитай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.</p> <p>Австрали болон Бүгд Найрамдах Казакстан улсын төлөөлөгч нар ТНАЛТ төсөлтэй танилцан харилцан туршлага судалсан.</p> <p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн хүрээнд АНУ-ын “Progress Rail A Caterpillar” компанийн мэргэжилтнүүд SD70Ace/LW зүтгүүрийн ашиглалтын үеийн заавар, зүтгүүрийн хангамж, дизелийн ажиллагаа, авто тоормос, явах ангийн бүтэц зохион байгуулалт, засвар үйлчилгээний талаарх сургалтыг зохион байгуулсан.</p>	100% ТХГ
5.4.	Мэдлэгийн менежментийн байгууллага болоход чиглэсэн “Суралцагч” байгууллагын хөгжлийн хөтөлбөр гаргасан байна.	Компанийн инновацийн хөгжилд хувь нэмэр оруулах байдал	<p>Төсөл, судалгааны хэлтсийн төслийн нэгж тус бүр хариуцан ажиллаж буй төслүүдийн судалгаа, тооцоолол, мэдээлэл зэрэг төсөлтэй холбоотой баримт бичиг бүхий мэдээллийн санг үүсгэсэн.</p> <p>“Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн” чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗУС, “Хөдлөх бүрэлдэхүүн угсрах үйлдвэр технологийн төв” төслийн ТЭЗУС боловсруулах ажлын хэсэгт тус бүрд гадны зөвлөх, салбарын эрдэмтэн судлаачдыг зөвлөхөөр ажиллуулж байна. Дээрхи 2 төслийн судалгааны мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.</p>	70% ТХГ
<b>Хэсгийн дундаж хувь:83%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-6: Компанийн хүний нөөцийн хөгжил</b>				
<i>Үр дүн: Төмөр замын бүтээн байгуулалт хэрэгжүүлдэг, тээврийн үйл ажиллагаагаар мэргэшсэн хүний нөөц бүрдсэн байх</i>				
6.1.	2022 онд 871 ажилтан 2024 онд 1239 ажилтан болно.	Хүний нөөцийн бүрдүүлэлт	2024 оны 03 дугаар улирлын байдлаар 750 үндсэн ажилтантай гэрээгээр 65 ажилтан ажиллаж байна.	100% ЗУГ
6.2.	Компанийн хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. Шаардлагатай мэргэжилтэй ажилтнууд ажиллах, амьдрах орчинг бүрдүүлсэн байна. Жилд дунджаар нийт ажилтны 30 хувь, үүнээс: - Мэргэжил олгох сургалтад 5 хувь	Ажилчдын нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлсэн байдал	<p>-Төслийн талбайд ажиллаж, амьдарч буй ажилтнуудын нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор ТТӨ-д 150, ГСӨ-д 58 ортой амрах байрыг ашиглалтад оруулсан.</p> <p>2023 онд нийт төлөвлөсөн 60 сургалтаас 41 сургалт зохион байгуулсан. Үүнээс: Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн А/11 дугаар тушаалаар 2024 оны сургалтын төлөвлөгөөг батлагдсан. Тайлант хугацаанд зохион байгуулагдсан дотоод сургалт нь төлөвлөгөөт 27, төлөвлөгөөт бус 7 сургалтын тус тус зохион байгуулан ажилласан. Мөн гадаад 1 төрлийн сургалтад 3 ажилтныг хамруулан ажилласан болно. Шинэ ажилтны чиглүүлэх сургалтад 204 ажилтныг хамруулсан. Нийт 889</p>	70% ЗУГ ХНСХ

	<ul style="list-style-type: none"> <li>- Хөгжүүлэх сургалтад 20 хувь</li> <li>- Мэргэшүүлэх сургалтад 5 хувь</li> </ul>		<p>ажилтныг сургалтад хамруулан ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт -81%-тай байна.</p> <p>Сургалтын задаргаа:</p> <p><b>Төлөвлөгөөт сургалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ ХЭМАБ чиглэлийн-12 сургалт;</li> <li>✓ Статистик систем хөгжүүлэлтийн хэлтэс-2 сургалт;</li> <li>✓ Захиргаа, эрх зүйн чиглэлээр-5 сургалт;</li> <li>✓ Төсөл хөтөлбөрийн чиглэлээр-2 сургалт;</li> <li>✓ Тээвэр зохион байгуулалт чиглэлээр-3 сургалт;</li> <li>✓ Зам барилга, дохиолол холбоо эрчим хүчний чиглэлээр-3 сургалт.</li> </ul> <p><b>Төлөвлөгөөт бус сургалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Авто зам, гүүрний хяналтын инженерийн итгэмжлэл олгох сургалт</li> <li>✓ Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 сарын 31-ний өдрийн А/17 дугаартай "Компанийн орон тооны зохион байгуулалт, албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжил шинэчлэн батлах тухай"-тушаалын танилцуулах сургалт</li> <li>✓ Худалдан авах ажиллагааны АЗ сургалт</li> <li>✓ Greenhouse gases Regulated Emission and Energy use inn Technologie</li> <li>✓ Усны сургалт "Water for peace"</li> <li>✓ Төрийн чадамжийг бүрдүүлэх нь</li> <li>✓ Хөдөлмөрийн хуулийн тухай сургалт</li> </ul> <p>Шинэ ажилтны чиглүүлэх сургалт-204 ажилтан хамруулсан.</p>	
6.3.	Ажилчдын тогтвортой ажил эрхлэлт	0.8	<p>Ажиллах хүчний эргэцийн тоо</p> <p><b>2021 он /12%/</b> Батлагдсан орон тоо 379 гүйцэтгэл 265 /Томилсон 140, чөлөөлсөн 26/</p> <p><b>2022 он /20%/</b> Батлагдсан орон тоо 883 гүйцэтгэл 644 /Томилсон 468, чөлөөлсөн 93/</p> <p><b>2023 он /25%/</b> Батлагдсан орон тоо 883 гүйцэтгэл 682 /Томилсон 211, чөлөөлсөн 168/</p> <p><b>2024 он /60%/</b> Батлагдсан орон тоо 883 гүйцэтгэл 750 /Томилсон 184, чөлөөлсөн 112/</p>	70% ЗУГ
6.4.	Хүний нөөцийн хөгжилд зориулах нийт төсвийн хөдөлмөрийн бус зардал	Нийт төсвийн зардлын 2 хувь	Компанийн хэмжээнд хүний хөгжлийн чиглэлээр 2024 оны Сургалтын төлөвлөгөөг гадаад 142,0 сая, дотоод 152,0 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсан.	100% ЗУГ
<b>Хэсгийн дундаж хувь:85%</b>				

<b>Тэргүүлэх чиглэл-7: Засаглал, менежментийн тогтолцоо</b> <i>Үр дүн: Төслийн менежментийн удирдлага бүхий шилдэг охин компани болсон байх</i>				
7.1.	Тулгуур бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг компани болсон байх	Засаглал, удирдлагын бүтцийг хөгжүүлсэн байдал	Өөрсдийн бий болгосон үйл ажиллагааны чиг хандлага, хөгжлийн загвар, нөөц боломж, туршлага, давуу талдаа тулгуурлан “төслийн удирдлагын үйл ажиллагаанаас-төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ үзүүлдэг” компани болж өсөн дэвших зорилт, зорилго тавьж хэрэгжүүлэх үүднээс урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Стратеги төлөвлөгөө-2050”, “Тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050”, “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг-2030” хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Компанийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлт III улирлын байдлаар 92,3 хувьтай байна.	90% ЗУГ
7.2.	Олон улсын стандарт нэвтрүүлэгч байгууллагын статустай болсон байна.	Удирдлага, зохион байгуулалтын тогтолцоонд олон улсын стандартуудыг нэвтрүүлсэн байдал	“Тавантолгой төмөр зам” ХХК “Сольюшн менежмент групп” ХХК-тай 2020 онд гэрээ байгуулан компанийн үйл ажиллагаанд ISO стандартуудыг нэвтрүүлэхээр хамтран ажиллаж эхэлсэн. Гүйцэтгэх захирлын тушаалаар Ажлын хэсэг байгуулах тухай, Хамрах хүрээ тодорхойлох тухай, Сургагч багш нарын нэрс, Дотоод аудиторчуудын нэрс зэрэг тушаалууд батлагдан гарсан. /Ковид-19/ цар тахалтай холбоотойгоор тус ажил түр зогсож хойшлогдсоор 2022 оны 04 дүгээр сард эрчимжиж Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. 2022 оны 04 дүгээр сарын 19-ний А/43 дугаар тушаалаар дотоод аудит хийх ажилтнуудын нэрсийг батлуулж баталгаажуулалтын аудитад бэлтгэх бэлтгэл ажил хийгдсэн. 2022.10.17-ны өдөр ISO 27001:2013, ISO21500:2012, ISO9001:2015, ISO14001:2015, ISO45001:2018 олон улсын стандартуудыг тус тус нэвтрүүлж, олон улсын баталгаажилтын гэрчилгээг хүлээн авсан болно.	90% ЗУГ
7.3.	Хувь оролцоонд өөрийн эзэмшлийн хувь 34 хувь байна.	Компанийн засаглалд өөрийн оролцоогоо нэмэгдүүлсэн байдал	“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дүрмийн 4.2-т “Компанийн зарласан энгийн хувьцаа нь нэг бүр нь 2,500 /хоёр мянга таван зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,403,820,000 /нэг тэрбум дөрвөн зуун гурван сая найман зуун хорин мянга/ ширхэг байна” гэж, 4.4-т “эргэлтэд гаргасан нийт 816,191,900 ширхэг хувьцаа байна” гэж тус тус заасан. Үүнээс үзвэл одоогийн байдлаар нийт 1,469,070,250,000 төгрөгийн үнийн дүнтэй 587,628,100 ширхэг хувьцааг эргэлтэд гаргаагүй гэж үзэж болохоор байна. Уг асуудлыг тухайд Компанийн дүрмийн 1.5-д “Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь хуульд өөрөөр заагаагүй бол хувьцааг захиран зарцуулахаас бусад хувьцаа эзэмшигчийн эрхийг дүрэмд заасны дагуу хэрэгжүүлнэ. Хувьцаа захиран зарцуулах эрх зөвхөн Монгол Улсын Засгийн газарт хадгалагдана” гэж заасан байдаг тул компанийн хувь оролцоонд өөрийн эзэмшлийн хувийг нэмэгдүүлэх буюу компанийн хувь эзэмшилд өөрчлөлт оруулах асуудлыг Монгол Улсын Засгийн газарт танилцуулан, шийдвэрлүүлэх шаардлага бий болно. Одоогийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолын дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 66%-	90% ЗУГ

			ийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 34%-ийг “Монголын төмөр зам” ТӨХК нар тус тус эзэмшиж байгаа хэвээр байна.	
7.4.	Компанийн өмнөх жилийн нийт ашгийн 0.3 хувь	Компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх	Тавантолгой өртөөн дээр 152 ажилчдын түр кемп, Гашуунсухайт өртөөн дээр 52 ажилчдын түр кемпийг байгуулж, ашиглалтад хүлээн авсан. Тавантолгой, Гашуунсухайт өртөөний болон амрах байрны тохижилтын ажлууд хийгдэж байна. Мөн Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн БО-ны асуудал эрхэлсэн газартай хамтран Аюултай хог хаягдал"-ын талаар сургалтыг 7 настай 32 сурагчдад зохион байгуулсан.	100% ЗУГ
<b>Хэсгийн дундаж хувь:93%</b>				
<b>Тэргүүлэх чиглэл-8: Санхүү, хөрөнгө оруулалт</b>				
<i>Үр дүн: Компанийн орлого, ашиг хуримтлалын дийлэнх хувийг үйл ажиллагааны бизнесээс бүрдүүлдэг болсон байна.</i>				
8.1.	1. 2022 онд 239.7 сая ам.доллар, 2024 онд 395.2 сая ам.доллар 2. 2022 онд 81.9 сая ам.доллар, 2024 онд 154.2 сая ам.доллар	Компанийн санхүүгийн үр дүн /хямдруулаагүй/	1.1. 2022 онд тээврийн үйл ажиллагаа болон төслийн үйл ажиллагаанаас нийт 8,071.33 сая.төгрөг буюу 2.57 сая ам.долларын борлуулалтын орлого олсон байна. 1.2. 2023 онд нийт 31,207.61 сая.төгрөг буюу 9.0 сая ам.долларын борлуулалтын орлого олсон байна. 1.3. 2024 оны хувьд III-р улирлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр борлуулалтын нийт орлого 92.17 тэрбум төгрөг байна. 2.1. 2022 онд (1,563.19) сая.төгрөг буюу (0.5) сая ам.долларын алдагдалтай байна. 2.2. 2023 онд 4,422.9 сая.төгрөг буюу 1.3 сая ам.долларын цэвэр ашигтай байна. 2.3. 2024 оны III-р улирлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 41.48 тэрбум төгрөгний цэвэр ашигтай ажилласан.	90% СТГ
8.2.	Одоогийн үйл ажиллагаанаас гадна суурь бүтэц, тээвэр, логистикийн үйлчилгээ	Санхүүгийн биеэ даасан байдлаа хангах бизнесийн боломжийн өргөжилт	2024 оны III-р улирлын байдлаар үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор: – Тээвэр зуучийн үйлчилгээ–6.8 тэрбум төгрөг; – Автын терминалын үйлчилгээ–8.8 тэрбум төгрөг; – Суурь бүтэц ашиглуулах үйлчилгээ–1.4 тэрбум төгрөг; – Суман шилжүүлэг арчлалтын үйлчилгээ–0.037 тэрбум төгрөг; – Түрээсийн үйлчилгээ–15.4 тэрбум төгрөгний орлогыг тус тус төвлөрүүлэн ажилласан үзүүлэлттэй байна.	100% СТГ
8.3.	Компанийн удирдлагын зарим чиг үүрэгт мэдээллийн технологид суурилсан ERP систем нэвтрүүлсэн байна.	Санхүү, хөрөнгө оруулалтын удирдлагад дижитал технологи ашиглах байдал	Тээврийн үйл ажиллагаанд программ хангамжийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор “ТТЗ” ХХК нь “Амирбаяр” ХХК-тай 2024.08.27-ны өдөр АГГ-2024/45 дугаар бүхий программ хангамж хийлгэх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна. Программ хангамжийг нэвтрүүлэхтэй холбоотой гэрээний үүргийг биелүүлэх, программ хангамжийг эцсийн байдлаар хүлээлцэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. 2024.11.04-ний өдрийн байдлаар суурь системийн шинжилгээ болон админы программ хангамж бүрэн хийгдсэн. Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалт болон зүтгүүрийн ашиглалтын программууд туршилтын байдлаар үйл ажиллагаанд нэвтэрсэн, хөгжүүлэлт хийгдэж байна.	50% ХНСХ СТГ



			Хүний нөөц, сургалтын хэлтэс нь Компанийн удирдлагын зарим чиг үүрэгт мэдээллийн технологид суурилсан able системийг 2024.03.01-ний өдрөөс эхлэн “Эйблсофт” ХХК-тай АГ-24/01 дугаартай гэрээ байгуулан нэвтрүүлэн ажиллаж байна. Гэрээний хүрээнд эйбл системд цаг бүртгэлийн программ, Хүний нөөцийн программын нэмэлт хөгжүүлэлтийг хийлгэн хяналт тавин ажиллаж байна.	
<b>Хэсгийн дундаж хувь:80%</b>				
<b>Хэрэгжилтийн дундаж хувь:88%</b>				

**ДҮГНЭЛТ:**

Тус хөтөлбөрийн хэрэгжилт 2024 оны III улиралын байдлаар нийт 9 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас

100% хэрэгжсэн-15;

90% хэрэгжсэн-8;

70% хэрэгжсэн-8;

50% хэрэгжсэн-3 нийт хэрэгжилт **88** хувьтай байгаа бөгөөд “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэй байна.

---ooOoo--